

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2020 ОНЫ ТАЙЛАН**

2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

1. Тус газарт 2020 оны байдлаар нийт 21 өргөдөл, гомдол, хүсэлт, 1 өргөдөл байгууллага андуурч тус тус ирсэн байна. 2018 оны байдалтай харьцуулахад өргөдөл, гомдол 2-оор бага байна.

Үзүүлэлт	2020.01.01-12.21		2019.01.01-12.11	
	Тоо	Шийдвэрлэлтийн хувь	Тоо	Шийдвэрлэлтийн хувь
Ирсэн өргөдлийн тоо	21	100%	23	95,6%

2. Тус газарт 1800-1200 тусгай дугаарын утаснаас 2 өргөдөл, Засгийн газрын 11-11 төвөөс 2 гомдол, НҮНТ-д бүртэгсэн 4 өргөдөл, гар утасны аппликейшнээр бүртгэсэн өргөдөл 3, ННЗБ бүртгэсэн 9 өргөдөл, гомдол тус газрын албан хаагчид буюу боловсон хүчинтэй холбоотой өргөдлийг тус тус бүртгэв.

3. Нийт ирсэн 21 өргөдлөөс 19-ийг хугацаанд нь 100%, 1 өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн. Газрын дарга болон Захиргааны хэлтсийн даргад өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар сар тутамд тайлан гарган танилцуулан ажиллаж байна. 1 өргөдөл байгууллага андуурч ирснийг буцаасан. Энэ хугацаанд хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл 1 байгааг Газрын хурлаар хэлэлцүүлэн албан хаагчид мэдэгдэх хуудас өгсөн болно.

4. Иргэдээс амралтын газар, зочид буудлын үйл ажиллагаатай холбоотой 15 гомдол ирснээс 4-ийг хуулинд заасан хугацаанд журмын дагуу, 1 гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэн албан байгууллагуудад мэдэгдэл, иргэдэд шийдвэрлэлтийн байдлыг албан бичгээр болон утасаар хүргүүлэн ажилласан, Аялал жуулчлалын салбартай холбоотой хамтран ажиллах санал 1, боловсон хүчинтэй холбоотой хүсэдт 4 тус тус ирсэн байна.

5. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хоног 13 хоног 12 цаг 30 минут байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар тухай бүр газрын хурлаар танилцуулж, НЗДТГ-ын Үйлчилгээний Нэгдсэн төвд улирал бүр өргөдөл гомдлын тайланг хугацаанд нь хүргүүлж байна.

6. Өргөдөл, гомдлын тоон тайлан, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлын жагсаалтыг хавсаргав.

ТАНИЛЦСАН
ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
ЭРХЛЭГЧ

Т.ТУУЛ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
2020 ОНЫ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн	Шийдвэрлэлтийн байдал
1	С.Батзориг	Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны Кибер /Анун/ төвийн 3 давхарт байрлах дэн буудал нь “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангахгүй байгаа тул үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгох боломжгүй болно. Стандартын шаардлагын дагуу засвар, үйлчилгээг сайжруулан дахин хүсэлт гаргах боломжтой. Зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа болон хууль бус гэмт хэргийн шинжтэй асуудлын талаар цагдаагийн байгууллагад хандахыг өргөдөл гаргасан иргэнд 2020 оны 07 сарын 06-ны өдрийн 17 цаг 20 минутад утсаар холбогдон мэдэгдэв. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
2	Б.Дэнсмаа	Хүсэлт гаргасан иргэнтэй холбогдож НИТХ-ийн 120 дугаар тогтоолын дагуу танилцуулан мөн Стандарт шаардлага хангахгүй байгаа аж ахуйн нэгжүүдэд зөвшөөрөл олгохгүй зөрчилтэй аж ахуйн нэгжүүдийн зөвшөөрлийг цуцлан арга хэмжээ авч ажиллаж байгаа тухай Иргэн Дэнсмаад мэдэгдсэн болно. 2019.12.30 16:14 минут. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
3	Б.Үржинханд	Б.Үржинхандын өөрийнх нь бичгээр гаргасан хүсэлтийн дагуу газрын даргын 2020 оны Б/01 тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлөв. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
4	Б.Сэржмядаг	2020 оны 02 сарын 03-ний өдөр Нийслэлийн цагдаагийн удирдах газарт 01/44 тоот албан бичгээр зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд байрлах Дэвжих жигүүр ХХК-ийн Ландыш дэн буудлын үйл ажиллагаанд хяналт тавин, хуулийн дагуу арга хэмжээ аван хамтарч ажиллахыг хүссэн албан бичгийг хүргүүлсэн. Хариу албан бичигт зөрчлийн хэрэг нээн шалгаж байгаа болон мөн авсан шийтгэлийн хуудсыг хавсарган ирүүлсэн. Гомдол гаргасан иргэн Сэржмядагтай 94112957 утсаар 2020 оны 02 сарын 17-ний өдрийн 10 цаг 20 минутад холбогдон өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, авсан арга хэмжээний талаар мэдэгдэж танилцуулав. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/

5	Ж.Чулуунтоого	2020 оны 04 сарын 07-ний өдрийн 14 цаг 20 минутад гомдол гаргасан иргэнтэй 96012508 дугаартай утсаар холбогдон Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 сарын 30-ний өдрийн А/436 тоот захирамжаар Коронавируст /КОВИД-19/ халдвараас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай захирамжаар олон нийтийг хамарсан хурал, жагсаал, цуглаан, тэмцээн, уралдаан, аялал зугаалга, сургалт, урлаг, соёл, спортын арга хэмжээ, бүх төрлийн тоглоомын газар, спорт, шашин, урлаг соёл, үзвэр үйлчилгээний газар /сүм хийд, мөргөлийн газрууд, цанын бааз, заал, биллиард, саун, бассейн, фитнес, бүжиг, иогийн клуб г.м/ болон амралт, жуулчны бааз, дэн буудлын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргасан байгаа талаар хэлж тайлбарлав. Таны гаргасан гомдлыг утсаар мэдэгдэн хааж байгааг мөн хэлж мэдэгдэв. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
6	О.Нямбат	Газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн Б/03 дугаар тушаалаар О.Нямбатыг Б.Халиуны хүүхэд асрах чөлөөлтэй байх хугацаанд Соёлын аялал жуулчлал, эвент арга хэмжээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд түр томилов. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
7	М.Болортуяа	Газрын даргын 2020 оны Б/04 дүгээр тушаалаар Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Мөнхбаярын Болортуяагийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу 2020 оны 04 сарын 08-ны өдрөөс хүүхэд асрах чөлөө олгов. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
8	Г.Дулмаа	2020 оны 05-р сарын 11-ний өдрийн А/31 дугаар тушаалаар 20/196 дугаартай зочид буудлын ангилалын зөвшөөрөл олгов. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
9	С.Батзориг	2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр өргөдөл, гомдлын дагуу Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Энхтуулын хамт Сүхбаатар дүүргийн 8-р хороонд байрлах Ийгл дуудлага сервис ХХК-ийн "Саруул" дэн буудал дээр очиж үзлэг, шалгалтыг хийлээ. Шалгалт хийхэд тус дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл 2020 оны 05 сарын 10-ны өдөр дууссан байсан тул Сүхбаатар дүүргийн Цагдаагийн I хэлтсийн эргүүлийн офицер, Цагдаагийн ахмад Ёндонпунцаг-т зөрчлийн мэдээллийг хүлээлгэн өгч шалгуулж байна.

		Цаашид тухайн дэн буудлын үйл ажиллагаанд хяналт тавьж нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтарсан шалгалтыг хийж байхаар шийдвэрлэв. Дэн буудлын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нийслэлийн Аялал жуулчлалын газраас сунгах боломжгүй болно. 2020 оны 05 сарын 27-ны өдрийн 17 цаг 30 минутад өргөдөл гаргасан иргэнтэй 90060008 дугаартай утсаар холбогдож хариу өгөхөөр залгасан боловч утсаа аваагүй болно. Утсаар болон мессежээр өргөдлийн хариуг мэдэгдэнэ. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
10	Н.Эрдэнэчимэг	2020 оны 05 дугаар сарын 19-ний А/34 дугаар тушаалаар зөвшөөрөл олгов. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
11	Д.Янжинхорлоо	2020 оны 06 сарын 02-ны өдрийн 01/190 тоот албан бичгээр өргөдлийн хариуг иргэн Д.Янжинхорлоод хүргүүлсэн. Иргэн Д.Янжинхорлоо нь 2020 оны 06 сарын 03-ны өдөр нэмэлт тайлбарыг гаргасан. Эйншэнт номадик ХХК, Проект менежмент ХХК, Нийслэл орд ХХК гэсэн 3 компанийн регистрийн дугааруудыг тодорхойлолтод оруулах хүсэлтийг гаргасан. Эншэнт номадс ХХК-ийн "Байкал" зочид буудал 2015 оны 05 сарын 25-ны өдөр 1 жилийн хугацаатай зөвшөөрөл авч байсан. Үүнээс хойш зөвшөөрөл авч байгаагүй болохыг 01/190 тоот албан бичгээр хариу өгсөн. Иймд Проект менежмент ХХК, Нийслэл орд ХХК нь тус газарт бүртгэлгүй тул тодорхойлолт гаргаж өгөх болон эдгээр компанийн регистрийн дугааруудыг оруулах боломжгүй байгаа болно. Өргөдлийн нэмэлт тайлбарын хариуг өгөхөөр 91111921 дугаартай утсанд 4 удаа залгахад хариу өгөөгүй. Дахин холбогдон утсаар хариуг мэдэгдэнэ. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
12	Р.Ёндон	2020 оны 06-р сарын 11-ны өдрийн 01/197 тоот албан бичгээр арга хэмжээ авхуулах тухай Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт илгээсэн. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
13	С.Сэржмядаг	2020 оны 07 сарын 09-ний өдөр нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн С.Туул , Сүхбаатар дүүргийн хоол үйлдвэрлэл, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Н.Оюунчимэг нар очиж стандартын үзлэг, шалгалтыг хийлээ.

		Шалгалтаар 75,2%-тай дүгнэгдсэн тул стандартын шаардлага хангахгүй байгаа заалтууд дээр сайжруулах зүйлийг хийж гүйцээх үүрэг даалгаврыг өгсөн. 14 хоногийн хугацаатай засах, үйлчилгээг сайжруулахтай холбоотой мэдэгдэх хуудсыг өгсөн болно. Стандартын шаардлагыг хангасан тохиолдолд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгоно. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг иргэнд утсаар болон биечлэн хэлж тайлбарласан болно. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
14	Э.Буянболд	Энхболдын Буянболдын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн газрын даргын 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар Мэдээлэл, сурталчилгааны төвийн Мэдээллийн ажилтны албан тушаалаас чөлөөлөв. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
15	З.Бямбасүрэн	2020 оны 09-р сарын 03-ний өдрийн 11 цаг 26 минутад Сүхбаатар дүүргийн эрүүл ахуй халдвар хамгааллын Улсын хяналтын байцаагч Д.Өлзийбаяртай холбогдон тухайн амралтын газрын зөрчлийн талаар мэдээлэл авахад Их Тамир амралтын газрыг хариуцсан захирал менежерүүд ирж уулзахгүй байгаа тул Сүхбаатар дүүргийн Порукроорийн газарт хэрэг нээн явуулсан тухай Гомдол гаргасан иргэнтэй 2020 оны 09-р сарын 03-ний өдөр 99948599 дугаар утсаар холбогдон авагдсан арга хэмжээний тухай мэдээлэл өгөв. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
16	Д.Наранбилэг	2020 оны 09-р сарын 04-ний өдрийн А/288 дугаартай албан тоотыг Нийслэлийн Цагдаагийн Удирдах газарт хүргүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллах тухай хүргүүлэв. 2020 оны 09-р сарын 04-ний өдрийн 17 цаг 02 минутад иргэн Д.Наранбилэгтэй 80711168 дугаар утсаар холбогдон мэдээлэл хүргэв. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
17	Б.Нямсүрэн	2020 оны 09-р сарын 04-ний өдрийн А/288 дугаартай албан тоотыг Нийслэлийн Цагдаагийн Удирдах газарт хүргүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллах тухай хүргүүлэв. 2020 оны 09-р сарын 04-ний өдрийн 17 цаг 02 минутад иргэн Б.Нямсүрэнтэй 95190645 дугаар утсаар холбогдон мэдээлэл хүргэв. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
18	М.Пүрэвсүх	Маргаантай байгаа газар нь "Рэд рок" амралтын газрын эзэмшлийн газар болно. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/

19	Д.Янжинхорлоо	Иргэн Д.Янжинхорлоод өргөдлийн хариуг 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 01/329 тоот албан бичгээр хариуг хүргүүлэв. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
20	Т.Баттогтох	Цаг үеийн нөхцөл байдал, цар тахлын хөл хорионы дэглэмийн улмаас уг өргөдлийг шууд шийдвэрлэх боломжгүй тул танилцаад хүлээлгийн байдалд шилжүүллээ. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/
21	Л.Дэлгэрсайхан	Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр хатуу хөл хорио, хорио цээрийн дэглэмд шилжин ажиллаж байгаа тул зөвшөөрөл олгох үйл ажиллагаа тодорхойгүй хугацаагаар хойшилсон байгаа тул шийдвэрлэх боломжгүй байна. /Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн/

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР